

116



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 114

Номгон

“Зөв-Амьдрал” дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, архины хор уршгийн талаар иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх, архигүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, зорилгоор “Зөв-Амьдрал” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг жил бүрийн аймгийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



0121244



## “ЗӨВ-АМЬДРАЛ” ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.3.4-т “ ... архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна.” гэж заасан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1.1 дэх заалтанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах талаар тусгасан.

Манай улсад спиртын 6, архины 26, шар айрагны 12, нийтдээ архи, согтууруулах ундааны 44 үйлдвэр байгаа бөгөөд энэ нь 2012 онд 75 байсантай харьцуулахад үйлдвэрийн тооны хувьд буурсан үзүүлэлттэй байна. Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр нэг хүнд ногдох архи, дарсны хэмжээ 2011 онд 10.6 литр, 2015 онд 7.2 литр байсан бол 2019 онд 8.5 литр, шар айрагны хэмжээ 2011 онд 28.1 литр, 2015 онд 25.3 литр байсан бол 2019 онд 28.8 литр болж манай улс нэг хүнд ногдох архины хэрэглээ Ази тивд дөрөвдүгээрт бичигджээ. Дээрх тооноос харахад үйлдвэрийн тоо буурсан ч архи, согтууруулах ундааны хэрэглээ төдийлөн буураагүй байна.

Аймгийн хэмжээнд гаргасан сүүлийн 3 жилийн гэмт хэргийн судалгаагаар 2017 онд 563 гэмт хэрэг үйлдэгдсэний 149 гэмт хэргийг согтуугаар, 2018 онд 581 гэмт хэрэг үйлдэгдсэний 113 гэмт хэргийг согтуугаар, 2019 онд 642 гэмт хэрэг үйлдэгдсэний 130 гэмт хэргийг согтуугаар тус тус үйлдсэн байна.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсанаас 2017 онд 1516 хүн, 2018 онд 1274 хүн, 2019 онд 1240 хүн тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд согтууруулах ундаа худалдах дэлгүүр, үйлчилдэг ресторан, баарны тоо нэмэгдэн одоо аймгийн төвд 11 ресторан, зоогийн газар, 13 караоке, баар, 17 супермаркет, 117 хүнсний дэлгүүр, бусад сумдад 195 хүнсний дэлгүүр, 2 караоке тус тус иргэдэд согтууруулах ундаа худалдаж, үйлчилж байна. Аймгийн хэмжээнд 8 сум 1000 хүн ам тутамд дээрх цэгийн тоог 4 байхаар тогтоосон стандартыг зөрчсөн байна.

№	Сумын нэр	Одоо үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо	Хүн амын тоо /2019 оны эцсээр/	Цэгийн байх ёстой стандарт	Хэтрүүлсэн цэгийн тоо
1	Баянхонгор сум	Ресторан-11 Караоке-13 Супермаркет-17 Хүнсний дэлгүүр-117	32,297	Хүнсний дэлгүүрийн байх ёстой стандарт	Тусгай зөвшөөрөлтэй Хүнсний дэлгүүрийн тоо 6-аар хэтэрсэн

		Нийт:158		128	
2	Баацагаан	8	3282	12	Хэтрээгүй.
3	Баянбулаг	9	1789	4	5
4	Баянговь	20	2986	8	12
5	Баянлиг	17	3860	12	5
6	Баян-Овоо	4	2594	8	Хэтрээгүй.
7	Баян-Өндөр	7	2650	8	Хэтрээгүй.
8	Баянцагаан	11	3592	12	Хэтрээгүй.
9	Богд	15	3127	12	3
10	Бөмбөгөр	6	3.323	12	Хэтрээгүй.
11	Бууцагаан	13	3703	12	1
12	Галуут	8	4112	16	Хэтрээгүй.
13	Гурванбулаг	13	2273	8	5
14	Жаргалант	8	2901	8	Хэмжээндээ
15	Жинст	7	2228	8	Хэтрээгүй.
16	Заг	6	2086	8	Хэтрээгүй
17	Өлзийт	6	3845	12	Хэтрээгүй.
18	Хүрээмарал	8	1793	4	4
19	Шинэжинст	20	2493	8	12
20	Эрдэнэцогт	8	4319	16	Хэтрээгүй.

Иргэдийн гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн байгууллагад өгсөн мэдээллийг агуулгаар нь авч үзвэл 2018 онд 2844 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас 1345 буюу 47.2% нь, 2019 онд 3282 дуудлага, мэдээллээс 1585 буюу 48.3% нь, 2020 онд иргэд, хуулийн этгээдээс 4844 мэдээлэл ирүүлснээс 2595 буюу 53.5%-ийг тус тус архидан согтуурсантай холбоотой мэдээлэл эзэлж байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагад ирсэн дуудлага, мэдээллийн 50% буюу 1/2 нь архидан согтуурсантай холбоотой байгаагаас үзэхэд архидан согтуурах нь гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллийн голлох хүчин зүйл болж байгааг илэрхийлж байна.

Улсын болон орон нутгийн түвшинд гэмт хэргийн гаралтыг хүн амтай нь харьцуулан үзэхэд Баянхонгор аймаг 10.000 хүнд ногдох гэмт хэргийн гаралтаар 21 аймгаас 9 дүгээрт бичигдэж байна. Энэ нь орон нутгийн дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

Архины хор хөнөөл, архидан согтуурахаас сэргийлэх талаар олон нийт ялангуяа өсвөр насныхны мэдлэг муу, төрийн байгууллагын албан хаагчдын зүгээс бусдыгаа уруу татаж архидах, архи огт хэрэглэдэггүй нэгнийгээ архиар шахах байдал хавтгайрсан, аймгийн хэмжээнд архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, хяналт тавих нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээ байхгүй, архины хэрэглээнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтэл ихээр гарч, архидан согтуурахаас сэргийлэх, тэмцэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, гэр бүлийн оролцоо хангалтгүй, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв, хөрөнгө дутагдалтай байна.

Согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдэж, хэрэглэгчид нь улам бүр залуужиж согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүний тоо төдийлөн буурахгүй, архинаас үүдэлтэй хүн амын өвчлөл, осол гэмтэл, нас баралт нэмэгдсээр байгаа нь хүний тогтвортой хөгжилд саад болж буй гол хүчин зүйлийн нэг болж иргэд, айл өрхийн

амьдрал улмаар аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хохирол учруулж байгаа нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж байна.

Цаашид архины хэрэглээг зохистой байдалд төлөвшүүлэх, архидан согтуурсанаас хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх хүн амын мэдлэг хандлагыг дээшлүүлэх, өсвөр үеийнхнийг тохиолдлоор согтууруулах ундааг сонирхон хэрэглэхээс сэргийлэх, архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих, эрүүл мэнд нийгмийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгох уг ажлуудад оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гэр бүл, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зэргээр архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх өнөөгийн арга барилыг өөрчлөн, шинэ арга, хандлагаар ажиллах шаардлагатайг нийгэм төр засгаас шаардаж байна.

Согтууруулах ундааны хүртээмж нэмэгдэхэд үүнийг дагаж хэрэглээ, нийгэмд учрах хор хөнөөл нь өсөн нэмэгддэг болохыг анхаарч хүртээмжийг хязгаарлах зохицуулалтын арга хэмжээ авах буюу согтууруулах ундаа зарах цаг, газрыг хязгаарлаж, согтууруулах ундаагаар худалдах, үйлчлэх цэгийн тоог бууруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Сүүлийн үед архины хор хөнөөлийн талаар насанд хүрэгчид, хүүхэд, өсвөр үеийнхний мэдлэг харьцангуй нэмэгдсэн хэдий ч өдөр тутмын амьдралд тохиолдох бэрхшээлийг даван туулах, байдлыг дүгнэн зөв сонголт хийх чадваргүй, амьдрах ухааны суурь боловсролгүй, гэрийн хүмүүжлийн доголдолтой байдал, эцэг эх, насанд хүрэгчдийн зохисгүй үлгэр дуурайллаас шалтгаалж өсвөр үе, залуусын дунд согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдсээр байна.

Мөн архидан согтуурахаас сэргийлэх, тэмцэх ажилд төрийн бус байгууллага, олон нийт, гэр бүлийн оролцоо хангалтгүй, гэр бүл, түүний гишүүдийн бие биедээ тавих анхаарал халамж суларч, архины хамааралтай болсныг архидан согтуурагч өөрөө болон түүний ойр дотнын хүмүүс хожуу ухаардаг зэрэг байдлаас архидан согтуурагчдын тоо буурахгүй өсөн нэмэгдэхэд нөлөөлж байна.

Нийт хүн амыг чөлөөт цагаа согтууруулах ундаагүйгээр өнгөрүүлэх үйлчилгээний газар, спорт, урлаг соёлын байгууллага байгуулж ажиллах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийг бүх шатны Хурал, Засаг дарга нар бодитойгоор дэмжиж, насанд хүрэгчдийн согтууруулах ундааны зохистой, соёлтой хэрэглээг нэмэгдүүлэх, нийт хүн амд архийг жигших үзлийг төлөвшүүлэх, архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж эмчлэх, хяналт тавих ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, энэ бүх үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гэр бүл, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зэргээр архидан согтуурахаас урьдчилан

сэргийлэх, хяналт тавих өнөөгийн байдлыг эрс шинэчлэн, шинэ арга барил, хандлагаар ажиллаж амьдарцгаахад “Зөв-Амьдрал” дэд хөтөлбөрийг зайлшгүй батлан хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

### **Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

2.1.Орон нутгийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн бодлогыг дэмжих, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдах.

2.2.Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.

2.3.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжинэ.

### **Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

“Зөв-Амьдрал” дэд хөтөлбөрийг 2021-2024 онуудад хэрэгжүүлнэ.

#### **Дөрөв. Хөтөлбөрийн зорилго**

Архидан согтуурсанаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх өсвөр үе, иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх замаар согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг тоог бууруулах, архинд донтсон хамааралтай болсон иргэдийг эрт илрүүлж эмчлэн хяналт тавьж тэдгээр иргэдийг нийгэмшүүлэх, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох, цэгийн тоог бууруулах, төрийн албан хаагчдын архины хэрэглээг бууруулж албан томилолт, амралт, зугаалгаар явахдаа архи огт хэрэглэдэггүй нэгнийгээ архиар шахдаг байдлыг таслан зогсоох, ард иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж архигүй орчин бий болгох зорилгоор архигүй баг, сум, байгууллага болох цаашид “Архины зохистой хэрэглээг бий болгох” үйлсийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

#### **Тав.Хөтөлбөрийн зорилт**

5.1.Өсвөр үе болон иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар архийг жигших сэтгэл зүйтэй болгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах.

5.2.“Архи байнга болон хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй иргэдийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих арга хэмжээг үр дүнтэй болгож, нийгэмшүүлэх

5.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог бууруулах, согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах

### **Зургаа. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

#### **Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

1.1.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, хамт олны архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагыг тодорхой болгон хамтын ажиллагааг сайжруулах;

1.2.Хүүхэд, залуусыг амьдрах арга ухаанд сургах, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, согтууруулах ундаагүй орчин бүхий үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээний газар, спорт, урлаг соёлын байгууллага байгуулж ажиллах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж хамтран ажиллах;

1.3.Архидан согтуурахтай тэмцэх санг бий болгох;

1.4.Архины хор уршиг, нийгэмд урчуулж буй сөрөг үр дагаврын талаар өсвөр үе, иргэдийн сэтгэл зан үйлд нөлөөлөх сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

1.5.Олон нийтийн газар, нийтийн эзэмшлийн болон гудамж талбай, орон сууцны орц, овоо толгод, хөшөө цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газарт согтууруулах ундаа хэрэглэж үүнээс шалтгаалан гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг байдлыг таслан зогсоох зорилгоор аймгийн хэмжээний гэрэлтүүлэг, камержуулалтын тоог нэмэгдүүлэх;

1.6.Ахуйн хүрээний архидалтын хүрээн дэх гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн чадавхжуулж, тохиолдол бүрт холбогдох этгээдийг эрүүлжүүлэх, эмчлэх соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

1.7.Хамт олноороо архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй, архигүй орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийг алдаршуулахын зэрэгцээ тэдний туршлагыг нийтэд сурталчилж дэлгэрүүлэх;

1.8.Нийт иргэд, гэр бүл, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагын архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих үүрэг хариуцлага, хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнг тооцох;

#### **Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

2.1.Архинд донтох өвчин эмгэгтэй болсон иргэдийг эмчлэх “Жаргалтай амьдрал төв”-ийн үйл ажиллагааны, бүтэц, орон тооны асуудлыг улсын төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх;

2.2.Согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэдэг, үүний улмаас гэмт хэрэг, зөрчилд холбогддог, сэтгэцийн хувьд архины хамааралтай болж донтох эмгэгтэй болсон иргэдийн судалгааг гаргаж, эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт

тавих арга хэмжээг үр дүнтэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.3.“Жаргалтай амьдрал төв”-ийн эмчилгээнд хамрагдаж архинаас гарсан иргэдийг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн материаллаг баазад түшиглэн мэргэжил олгох сургалтад хамруулж, нийгэмшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах;

2.4. Донтолтын тусламж үйлчилгээг сумын эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлж, хөгжүүлэх;

2.5.“Жаргалтай амьдрал төв”-ийн эмчилгээнд хамрагдаж архинд донтох эмгэгээсээ салсан иргэдийн сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүрийн 12 дугаар сард “Өөрийгөө ялсан хүн” арга хэмжээг зохион байгуулж, улсын хэмжээнд сурталчлах;

2.6.Архинд донтох өвчтэй хvн болон түүний гэр бүлийнхэнд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, энэ чиглэлээр гэр бүл, төрөл, садан, хамт олны нөлөөлөл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

2.7.Архины хамаарлаа шийдвэрлэсэн болон эрсдэл бүхий хүмүүсийг дахин архи уухаас өөрийгөө хамгаалах арга ухаанд сургах, үүнд мэргэжлийн баг туслалцаа үзүүлэх, бүрэн эдгэрэл өгсөн иргэдээр дамжуулж нийгэмд, гэр бүлд соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

#### **Гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

3.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн а/272 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгийн тоог үе шаттайгаар бууруулах ажлыг зохион байгуулах;

3.2.Архи,согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, илэрсэн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах;

3.3.Хууль бусаар зөвшөөрөлгүйгээр гар дээрээс архи, согтууруулах ундаа худалдах, стандартын бус архи, согтууруулах ундаа худалдах зөрчилтэй тууштай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой хэрэгжүүлэх;

#### **Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт**

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн акт болон бусад баримт бичигтэй уялдана.

7.2.Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар батална. Зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогч ахлах бөгөөд

бүрэлдэхүүнд нь аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн дарга нар, сумдын Засаг дарга, орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд байна.

7.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн бүх сумдад салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг сумдын Засаг дарга нар ахалж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл байна.

7.4.Дэд хөтөлбөрийн холбогдох заалтуудыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, агентлагийн дарга нар болон сумдын Засаг дарга нартай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

7.5.Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлтийг зөвлөлөөр хэлэлцэн, аймгийн Засаг дарга баталгаажуулж сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллана .

### **Найм. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат**

8.1.“Зөв-Амьдрал” дэд хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг жил бүр хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, цаашид авах арга хэмжээг боловсруулж ажиллана.

Нэгдүгээр үе шат 2020-2021 он /2021 оны 12 сард үнэлгээ хийх/

Хоёрдугаар үе шат 2021-2022 он /2022 оны 12 сард үнэлгээ хийх/

Гуравдугаар үе шат 2022-2023 он /2023 оны 12 сард үнэлгээ хийх/

Дөрөвдүгээр үе шат 2023-2024 он /2024 оны 12 сард үнэлгээ хийх/

8.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг зөвлөл болон салбар зөвлөлийн дарга аймгийн Засаг даргад мэдээлж тайлагнана.

8.3.Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг зөвлөлийн дарга холбогдох албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлж ажиллана.

### **Ес. Хөтөлбөрийн санхүүжилт**

9.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

9.1.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

9.1.2.Орон нутгийн төсвийн хөрөнгө

9.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар улсын төсвөөс орон нутагт тусгагдсан хөрөнгө, тоног төхөөрөмжийн дэмжлэг

9.1.4.Бусад эх үүсвэр

9.2.Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн аж ахуйн нэгжийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай хослуулан хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

### **Арав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

Дэд хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

10.1. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын тоо



10.2.Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн иргэдийн бууралтын тоо

10.3. “Жаргалтай амьдрал” төвд эмчлүүлж архинд донтох өвчин эмгэгээсээ салан эрүүл зан үйлтэй болж ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн тоо

10.4.Согтуугаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон төрийн албан хаагчдын бууралтын тоо

10.5.Архины хор уршиг, нийгэмд урчуулж буй сөрөг үр дагаврын талаар өсвөр үе, иргэдийн сэтгэл зан үйлд нөлөөлөх чиглэлээр хийж буй сургалтын тоо

10.6.Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн цэгийн тоог хэтрүүлсэн сумдын цэгийн тооны бууралтын тоо

10.7.Аймгийн хэмжээний бүх төрийн байгууллагын албан хаагчдаас жил бүр авах албан томилолт, амралт зугаалгын үеэр архи огт хэрэглэдэггүй нэгнийгээ архиар шахдаг байдал таслан зогсоогдсон эсэх талаарх санал асуулгын дүн

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_